**МОНГОЛ УЛСЫН**
**ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН**
**ТУШААЛ**

2022 оны 12 сарын 05 өдөр　　　Дугаар А/577　　　Улаанбаатар хот

“Элэг бүтэн Монгол” арга хэмжээний
төлөвлөгөө (2022-2025) батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсыг 2022-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”- ийн 2.2.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”- ний 2.1.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Элэг бүтэн Монгол арга хэмжээний төлөвлөгөө (2022-2025)-г нэгдүгээр, шалгуур үзүүлэлтийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд нэгдсэн удирдлага, мэргэжил арга зүйгээр ханган ажиллахыг Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газар /Ж.Нарангэрэл/-т, Нийтийн эрүүл мэндийн газар /Д.Баярболд/-т, хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулж ажиллахыг Халдварт өвчин судлалын үндэсний төв /Ц.Билэгтсайхан/-д тус тус даалгасугай.

3. Тушаалыг хэрэгжүүлж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, өмчийн хэлбэр харгалзахгүй бүх шатлалын эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

4. Төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил бүрийн 12 дугаар сарын 01-ний дотор Халдварт өвчин судлалын үндэсний төв /Ц.Билэгтсайхан/-д ирүүлэхийг аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, өмчийн хэлбэр харгалзахгүй бүх шатлалын эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

5. Төлөвлөгөөний хэрэгжилтийн нэгдсэн тайланг жил бүрийн 12 дугаар сарын 15-ны дотор Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газар /Ж.Нарангэрэл/-т, Нийтийн эрүүл мэндийн газар /Д.Баярболд/-т ирүүлэхийг Халдварт өвчин судлалын үндэсний төв /Ц.Билэгтсайхан/-д үүрэг болгосугай.

141222773

6. Төлөвлөгөөнд заасан арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулж, шаардагдах зардлыг улс, орон нутгийн төсөв, хамтын ажиллагаатай улс орон болон олон улсын байгууллагын зээл, тусламжид хамруулан төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд шийдвэрлэх замаар санхүүжүүлж, үр дүнг тайлагнаж ажиллахыг Аймаг, нийслэлийн Засаг дарга нарт зөвлөсүгэй.

7. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /С.Төгсдэлгэр/-т даалгасугай.

САЙД С.ЭНХБОЛД

Эрүүл мэндийн сайдын 2022 оны 12 сарын 05 өдрийн А/472 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

## "ЭЛЭГ БҮТЭН МОНГОЛ" АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ (2022-2025)

| Үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилт | № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Эх үүсвэр | Нийт хөрөнгийн хэмжээ, (сая төгрөг) 2022-2025 | Суурь түвшин | Зорилтот түвшин, үр дүн (сая. төг) | | | | | | | | Хэрэгжүүлэх байгууллага | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 2022 он | Төсөв, сая.төг | 2023 он | Төсөв, сая.төг | 2024 он | Төсөв, сая.төг | 2025 он | Төсөв, сая.төг | Үндсэн | Хамтрагч |
| Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.2 дугаар зорилт: "Элэг бүтэн Монгол" арга хэмжээний үр ашиг, өгөөж, хүртээмжийг нэмэгдүүлж, элэгний Дельта вирусийн халдвартай иргэдийн 50-аас дээш хувийг эмчилгээнд хамруулж, хорт хавдрын эрт илрүүлгийг олон улсын жишигт хүргэнэ. | | | | | | | | | | | | | | | | |
| Зорилго: Гепатитын вирусийн халдварыг эрт илрүүлэх, оношилох, эмчлэх, тусламж үйлчилгээний төвлөрлийг сааруулан чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, элэгний архаг үрэвсэл, хатуурал, хорт хавдрын хяналт, тандалтыг сайжруулах, цахимжуулах, халдвар тархах эрсдэлийг бууруулан тархалтыг хязгаарлана. | | | | | | | | | | | | | | | | |
| Зорилт 1: Гепатитын вирусийн халдвараас сэргийлэх эрүүл мэндээ хамгаалах зөв дадал хэвшилд иргэдийг сургах, дархлаажуулалтыг өргөжүүлэх, халдвараас сэргийлэлэх, хянах цогц арга хэмжээг хэрэгжүүлэн хүн амын халдвар авах эрсдэлийг бууруулна. | | | | | | | | | | | | | | | | |
| Эрүүл мэндийн байдал, эрхэлдэг ажил хөдөлмөр, амьдралын хэв маяг, зан үйлээс хамааран гепатитын вирусийн халдварт өртөх эрсдэлтэй болон нийт хүн амд чиглэсэн мэдээлэл, сургалт, сурталчилгааг зохион байгуулах. | 1 | Эрсдэлт бүлгийн хүн амд чиглэсэн шинэ аргачлал, технологид суурилсан мэдээлэл, сурталчилгааг зохион байгуулах. | 2022-2025 | ОУБ | 139 | 0 | Олон улсын туршлага, арга технологийг судалж, мэдээлэл, сурталчилгааны цахим загваруудыг боловсруулж, ЭМЯ-ны сайтанд байршуулсан байна. | 13 | Элэг бүтэн Монгол нэвтрүүлэг бүтээсэн байна. | 60 | Гемодиализ, дархлаа дарангуйлах, цус, цусан бүтээгдэхүүн сэлбэх эмчилгээ хийлгэдэг иргэдэд болон эрүүл мэнд, шивээс, гоо сайхан, бариа засал эмчилгээний мэргэжилтнүүдэд сурталчилгаа зохион байгуулна. | 33 | Эрэгтэйчүүдтэй бэлгийн хавьталд ордог эрэгтэйчүүд, эмэгтэй биеэ үнэлэгчид, засан хүмүүжүүлэх газрын хүмүүжигчид чиглэсэн мэдээлэл сурталчилгаа зохион байгуулсан байна. | 33 | НЭМҮТ | ХӨСҮТ ЦССҮТ ХСҮТ УНТЭ ШШГЕГ ТББ |
| | 2 | Гепатитын В, С, Дельта вирусийн халдварт өртөх эрсдэлээс сэргийлэх талаар залуучуудад чиглэсэн мэдээлэл сурталчилгаа зохион байгуулах. | 2022-2025 | ОУБ | 191 | | МСС-ны ажил зохион байгуулах, ДЭМБ-ын санхүүжилтээр хийгдсэн байна. | 11 | Өсвөр үе, оюутан залуучуудаас үе тэнгийн сургагч, эрүүл мэндийн сайн дурын идэвхтэн бэлтгэх сургалтын модуль боловсруулсан байна. | 60 | Үе тэнгийн сургагч, сайн дурын идэвхтэнээр дамжуулан 6 аймаг, нийслэлийн 6 дүүрэгт сургалт зохион байгуулсан байна. | 60 | Үе тэнгийн сургагч, сайн дурын идэвхтэнээр дамжуулан 12 аймаг, 9 дүүрэгт сургалт зохион байгуулсан байна. | 60 | НЭМҮТ | МУЗН ХӨСҮТ |
| | 3 | Жирэмсний хяналтын зөвлөгөө, шинжилгээгээр гепатитын В, С, Дельта вирусийн халдварт өртөх эрсдэлээс сэргийлэх талаар жирэмсэн эмэгтэйчүүдэд мэдээлэл сурталчилгаа зохион байгуулах. | 2022-2025 | ОУБ | 110 | | Эхээс хүүхдэд гепатитын В вирусийн халдвар дамжихаас сэргийлэх сургалт сурталчилгааны материал боловсруулж орон нутагт тараагдсан байна. | 30 | Эрүүл мэндийн ажилтныг жирэмсэн эмэгтэйчүүдэд зөвлөгөө, мэдээлэл өгөх ур чадварт сургах сургалтын модуль, материал боловсруулж, түгээсэн байна. | 25 | Жирэмсний хяналтын явцад жирэмсэн эмэгтэйчүүдэд зөвлөгөө, мэдээлэл, сургалтыг хийж хэвшүүлсэн байна. | 25 | Жирэмсний хяналтын явцад жирэмсэн эмэгтэйчүүдэд зөвлөгөө, мэдээлэл, сургалт хийж байгаа явцад дэмжлэгт хяналт хийсэн байна. | 30 | ЭХЭМҮТ НЭМҮТ | ХӨСҮТ |

| | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Гепатитын В вирусийн эсрэг дархлаажуулалтын хамралтыг нэмэгдүүлэх | 1 | Гепатитын В вирусийн вакцин, иммуноглобулин, тавт вакцины хамралтыг үнэлэх | 2022-2025 | ДЭМБ Дэмжих сан Орон нутгийн сан | 370 | 98.5% 96.4% | | | Гепатитын В вирусийн халдвартай эхээс төрсөн нярайг 12 цагийн дотор вакцин болон гепатит В вирусийн эсрэг иммуноглобулинаар дархлаажуулсан байдалд хяналт, үнэлгээ хийсэн байна. Гепатитын В вирусийн эсрэг тавт вакцины 3 дахь тунгийн хамралтын тоон мэдээнд дүн шинжилгээ хийсэн байна. | 100 | Тавт вакцины дархлаажуулалтын хамралтыг үнэлсэн байна. | 50 | Тав хүртэлх насны хүүхдийн дундах HBsAg-ийн тархалтын үндэсний судалгааг хийсэн байна. | 220 | ХӨСҮТ | Аймаг, нийслэлийн ЭМГ Эрүүл мэндийн байгууллага АШУҮИС |
| | 2 | Гепатитын В вирусийн вакцины сайн дурын дархлаажуулалтын хамралтыг нэмэгдүүлэх. | 2022-2025 | Улсын төсөв Дэмжих сан Орон нутгийн сан | 127.3 | | Шинээр ажилд орж байгаа эрүүл мэндийн ажилтныг гепатитын В вирусийн эсрэг вакцины 3 тунгаар дархлаажуулах, эрсдэлтэй бүлгийн хүн амд сайн дурын дархлаажуулалтыг зохион байгуулсан байна. | 31.5 | Шинээр ажилд орж байгаа эрүүл мэндийн ажилтныг гепатитын В вирусийн эсрэг вакцины 3 тунгаар дархлаажуулах, эрсдэлтэй бүлгийн хүн амд сайн дурын дархлаажуулалтыг зохион байгуулсан байна. | 31.8 | Анагаах ухааны чиглэлийн их, дээд сургууль, коллежийн оюутныг гепатитын В вирусийн эсрэг вакцины 3 тунгаар дархлаажуулах ажлыг хэрэгжүүлсэн байна. Холбогдох эрхзүйн баримт бичиг шинэчлэгдсэн байна. | 32 | Насанд хүрэгчдэд товлолоор хийх ГВВ-ийн вакцины хэрэгцээ шаардлага, үндэслэлийг судалсан байна. Холбогдох эрхзүйн баримт бичиг шинэчлэгдсэн байна. | 32 | ХӨСҮТ | Аймаг, нийслэлийн ЭМГ, Эрүүл мэндийн байгууллага |
| Эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой халдвараас сэргийлэх, аюулгүй тарилга, цусны аюулгүй байдлыг сайжруулах, гепатитын вирусийн халдвар дамжих эрсдэлийг бууруулах чиглэлээр эрүүл мэндийн ажилтныг чадавхжуулах. | 1 | Улсын болон хувийн хэвшлийн ЭМБ-ын халдварын сэргийлэлт, хяналтын үнэлгээг тогтмолжуулах. | 2022-2025 | ОУБ Дэмжих сан Орон нутгийн сан | 70 | | | | Эх барих, эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээний халдварын сэргийлэлт, хяналтын үйл ажиллагааг үнэлнэ. | 20 | Мэс засал, гоо сайхны мэс заслын тусламж үйлчилгээний халдварын сэргийлэлт, хяналтын үйл ажиллагааг үнэлнэ. | 25 | Шүдний тусламж үйлчилгээний халдварын сэргийлэлт, хяналтын үйл ажиллагааг үнэлнэ. | 25 | ХӨСҮТ НЭМГ | Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн байгууллага |
| | 2 | Эрүүл мэндийн ажилтнуудыг халдварын сэргийлэлт хяналтын чиглэлээр чадавхжуулах | 2022-2025 | ОУБ Дэмжих сан Орон нутгийн сан | 60 | | | | Шүд, эх барих, эмэгтэйчүүд, уламжлалт анагаах ухаан, мэс заслын тусламж үйлчилгээ үзүүлдэг улсын болон хувийн хэвшлийн эмнэлгүүдийн эмч, ажилтнуудыг халдварын сэргийлэлтийн хяналтын чиглэлээр үе шаттайгаар сургалтад хамруулна. | 20 | Шүд, эх барих, эмэгтэйчүүд, уламжлалт анагаах ухаан, мэс заслын тусламж үйлчилгээ үзүүлдэг улсын болон хувийн хэвшлийн эмнэлгүүдийн эмч, ажилтнуудыг халдварын сэргийлэлтийн хяналтын чиглэлээр үе шаттайгаар сургалтад хамруулна. | 20 | Гоо сайхны үйлчилгээ үзүүлэгчдийг халдварын сэргийлэлт, хяналтын сургалтад хамруулах, энэ чиглэлээр сургалтад хамрагдсан байхыг шаардах эрх зүйн орчин бүрдүүлэх | 20 | ХӨСҮТ НЭМГ | Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн байгууллага |

| | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 3 | Эрүүл мэндийн байгууллагын халдварын сэргийлэлт, хяналтын үйл ажиллагаанд дэмжлэгт хяналт хийх. | 2022-2025 | ОУБ Дэмжих сан Орон нутгийн сан | 35 | | | | Эрүүл мэндийн байгууллагын халдварын хяналтын үйл ажиллагаанд дотоод хяналт хийх сургалтын багц боловсруулж, хүргэсэн байна. | 5 | Төрийн, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагыг дэмжлэгт хяналтад хамруулсан байна. | 10 | Төрийн, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагыг дэмжлэгт хяналтад хамруулсан байна. | 20 | ХӨСҮТ НЭМГ | Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн байгууллага |
| | 4 | Эрүүл мэндийн ажилтнуудын Гепатитын вирусийн халдварын илрүүлэг, сэргийлэлт, эрсдэлт хүчин зүйлд өртөлтийн мэдээ, мэдээллийг одоогийн цахимд нэгтгэх. | 2022-2025 | Улсын төсөв Дэмжих сан ОУБ | 65 | | | | Цахим системд нэгтгэх боломжийг судлаж журам/удирдамжаар зохицуулан шийдвэр гаргасан байна. | 5 | Цахим системд нэгтгэх үйл ажиллагааг мэргэшсэн, төв эмнэлгүүд, нийслэлийн дүүргийн эмнэлгүүдэд нэвтрүүлсэн байна. | 20 | Цахим системд нэгтгэх үйл ажиллагаар орон нутгийн ЭМБ, ор бүхий хувийн хэвшлийн эмнэлгүүдэд нэвтрүүлсэн байна. | 40 | ЭМЯ ХӨСҮТ НЭМГ | Төрийн, хувийн хэвшлийн аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн байгууллага |
| Эхээс хүүхдэд гепатитын B,C вирусийн халдвар дамжихаас урьдчилан сэргийлэх, тандалт, хяналтыг сайжруулах | 1 | Жирэмсэн эмэгтэйчүүдэд хийх вируст гепатитын халдварын илрүүлэг, тандалт, хяналтыг сайжруулах. | 2022-2025 | Улсын төсөв Дэмжих сан Орон нутгийн сан ДЭМБ | 115 | | Жирэмсэн эмэгтэйчүүдэд хийх вируст гепатитын халдварын илрүүлэг, хяналтын өнөөгийн байдлыг үнэлсэн байна. | 25 | Гепатитын B, C вирусийн халдвартай жирэмсэн эхийн илрүүлэг,тандалт бүртгэл мэдээлэл, эмчилгээ, хяналтын тогтолцоог сайжруулсан байна. | 20 | Гепатитын B, C вирусийн халдвартай жирэмсэн эхийн илрүүлэг, тандалт, бүртгэл мэдээлэл, эмчилгээ, хяналтын тогтолцоонд дэмжлэгт хяналт хийсэн байна. | 35 | Гепатитын B, C вирусийн халдвартай жирэмсэн эхийн илрүүлэг, тандалт бүртгэл мэдээлэл, эмчилгээ, хяналтын тогтолцоог бэхжүүлсэн байна. | 35 | ЭМЯ ЭХЭМҮТ ХӨСҮТ | Аймаг нийслэлийн ЭМГ, НЭ Амаржих газар, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг |
| | 2 | Гепатитын B вирусийн халдвартай эхээс төрсөн хүүхдэд хийсэн дархлаажуулалт [төрсний дараах 12 цагийн дотор гепатитын B вирусийн эсрэг вакцины эхний тунг, B вирусийн эсрэг өвөрмөц иммуноглобулинтай хамт хийнэ], лабораторийн шинжилгээ [6 сартайд HBsAg, HBsAb, HbcAb илрүүлнэ]-ний хамралтыг үнэлэх. | 2022-2025 | Дэмжих сан ДЭМБ ОУБ | 85 | | | | Гепатитын B вирусийн халдвартай эхээс төрсөн нярайг 12 цагийн дотор вакцин болон гепатит B вирусийн эсрэг иммуноглобулинаар хийх дархлаажуулалтын байдалд үнэлгээ хийж, хамралтыг нэмэгдүүлсэн байна. | 25 | Гепатитын B вирусийн халдвартай эхээс төрсөн хүүхдэд лабораторийн шинжилгээгээр 6 сартайд HBsAg, HBsAb, HbcAb илрүүлэх, хамралтыг үнэлсэн байна. | 30 | Эхээс хүүхдэд Гепатитын B вирусийн халдвар дамжих замыг таслан зогсоох журмын хэрэгжилтийг үнэлж, тогтолцоог бэхжүүлсэн байна. | 30 | ХӨСҮТ | Аймаг нийслэлийн ЭМГ, НЭ Амаржих газар төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг |
| | 3 | Гепатитын C вирусийн халдвартай эхээс төрсөн хүүхдэд 3 настайд aHCV илрүүлэг шинжилгээ хийж эхээс хүүхдэд халдвар дамжсан эсэхэд тандалт хийх. | 2022-2025 | Дэмжих сан ДЭМБ ОУБ | 83 | | | | Жирэмсний хяналтын болон хүүхдийн эмч нарт зориулсан сургалтын багц боловсруулж, тандалт хийх арга зүйн сургалт зохион байгуулсан байна. | 28 | Гепатитын C вирусийн халдвартай эхээс төрсөн хүүхдийг илрүүлэг шинжилгээ, эхээс хүүхдэд халдвар дамжсан эсэхэд хяналт үнэлгээ хийсэн байна. | 30 | Тандалтын тогтолцоог сайжруулж, тандалт судалгаанд хамруулах заавар/удирдамжийн хэрэгжилтийг үнэлсэн байна. | 25 | ХӨСҮТ | Аймаг нийслэлийн ЭМГ, НЭ Амаржих газар төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг |

| | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 4 | Жирэмсний хяналт болон төрсний дараах эмчилгээний хамрагдалтыг нэмэгдүүлэх, үйл ажиллагаанд хийх дэмжлэгт хяналт хийх. | 2022-2025 | Дэмжих сан ДЭМБ ОУБ | 50 | | | | Сонгосон эрүүл мэндийн байгууллагад дэмжлэгт хяналт хийж, ажлын байран дах сургалт зохион байгуулсан байна. | 10 | Гепатитын вирусийн халдвартай эхийн хэвтлыг тандалт судалгаанд журам /удирдамжаар зохицуулах хамруулах шийдвэр гаргасан байна. | 20 | Жирэмсний хяналт болон төрсний дараах эмчилгээний хамрагдалтыг нэмэгдүүлэх, хяналтыг сайжруулсан байна. | 20 | ХӨСҮТ ЭХЭМҮТ | Аймаг нийслэлийн ЭМГ, НЭ Амаржих газар төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг |
| | 5 | Тэмбүү, ХДХВ, гепатитын B, C вирусийн халдвар эхээс хүүхдэд дамжихыг таслан зогсоосон ДЭМБ-ын үнэлгээнд хамрагдах. | 2022-2025 | Дэмжих сан ДЭМБ ОУБ Глобал сан | 190 | | | | ДЭМБ-ын НДББ-ийн үнэлгээнд хамрагдсан байна. Эрүүл мэндийн ажилчдад тасралтгүй сургалт зохион байгуулсан байна. | 100 | Үнэлгээний дүнд тулгуурлан Тэмбүү, ХДХВ, гепатитын B, C вирусийн халдвар эхээс хүүхдэд дамжихыг таслан зогсоох үйл ажиллагааны төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, батлагдсан байна. Эрүүл мэндийн сайдын 614 тушаалын хэрэгжилтэд дэмжлэгт хяналт хийнэ, тушаалыг шинэчилсэн байна. | 34 | Тэмбүү, ХДХВ, Гепатитын B, C вирусийн халдвар эхээс хүүхдэд дамжихыг таслан зогсоох үйл ажиллагааны төлөвлөгөөг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх арга зүйгээр хангасан байна. | 56 | ЭМЯ ХӨСҮТ ЭНЭҮТ | Аймаг нийслэлийн ЭМГ, НЭ Амаржих газар төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг |
| **Зорилт 2: Гепатитын B, C, Дельта вирусийн халдварын тандалт, илрүүлэг, оношилгоо, эмчилгээ, хяналтыг сайжруулж, хүн амд чанартай багц тусламж, үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэнэ.** | | | | | | | | | | | | | | | | |
| Гепатитын B, C, Дельта вирусийн халдварын тусламж үйлчилгээний зураглалыг гарган, удирдамж шинэчлэн, эрсдэлт бүлэгт чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулна. | 1 | Өндөр эрсдэлт бүлгийн хүн амд чиглэсэн зорилтот бүлэгт үнэлгээ хийх. | 2022-2025 | Дэмжих сан Глобал сан ОУБ | 165 | | | | Мансууруулах бодис хэрэглэгчдийн талаарх мэдээлэл солилцох сонирхогч талуудын уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулсан байна. | 30 | Өндөр эрсдэлт бүлгийн дунд (Мансууруулах бодис хэрэглэгч, мансууруулах бодис судсаар тарьж хэрэглэгч) гепатитын халдварын тохиолдлын эзлэх хувийг судалсан байна. | 35 | ХДХВ-ийн халдвартай амьдарч байгаа иргэдийн гепатитын C вирусийн халдвар илрүүлэх шинжилгээнд хамруулах, бүрэн эмчлэгдсэн хувийг тодорхойлсон байна. | 100 | ЭМЯ СЭМҮТ НЭМҮТ НЯТТ ХЯТҮТ | ХЗДХЯ ХӨСҮТ ЦЕГ |
| | 2 | Гепатитын B, C, Дельта вирусийн халдварын тусламж үйлчилгээний зураглал (каскад) улс, аймаг, дүүргийн хэмжээнд гаргах. | 2022-2025 | Дэмжих сан ДЭМБ | 30 | B вирусын эсрэг эмчилгээнд хамрагдсан өвчтөний эзлэх хувь 41 хувь | | | Гепатитын B, C, Дельта вирусийн халдварын тусламж үйлчилгээний зураглал улсын хэмжээнд гаргасан байна. | 10 | Гепатитын B, C, Дельта вирусийн халдварын тусламж үйлчилгээний зураглал улсын хэмжээнд гаргасан байна. | 10 | Гепатитын B, C, Дельта вирусийн халдварын тусламж үйлчилгээний зураглал улсын хэмжээнд гаргасан байна. | 10 | ЭМЯ ХӨСҮТ НЭМГ | Аймаг нийслэлийн ЭМБ |

| | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 3 | Хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан эсхүл тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоог зохион байгуулах. | 2022-2025 | Эрүүл мэндийн даатгалын сан Дэмжих сан | 295 | | | | | Гепатитын В, С, дельта вирусийн халдварт эрсдэлт бүлгийн иргэдийг гепатитын В, С вирусийн халдвар илрүүлэх шинжилгээнд хамруулах журам батлан үзлэг шинжилгээнд хамруулсан байна. | 185 | Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг шинжилгээгээр гепатитын В, С, дельта вирусийн халдвартай нь шинээр илэрсэн иргэд, тэдгээрийн хавьтлыг тандалт судалгаанд хамруулсан байна. | 10 | Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг шинжилгээгээр гепатитын В, С, дельта вирусийн халдвартай нь шинээр илэрсэн тохиолдлын тандалтын байдалд үнэлгээ хийсэн байна. | 100 | ЭМЯ ЭМДЕГ | ЭМХТ ХӨСҮТ |
| | 4 | Гепатитын вирусийн цочмог халдвар, гепатитын В, С, Дельта вирусийн архаг халдварын тандалт, илрүүлэг, оношилгоо, эмчилгээ, хяналтын удирдамжийг шинэчлэн боловсруулж, мөрдөнө. | 2022-2025 | Дэмжих сан ОУБ ДЭМБ | 195 | | | | | Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг байгуулж, тандалт, илрүүлэг, оношилгоо, эмчилгээ, хяналтын удирдамжийг шинэчлэн боловсруулж, Эрүүл мэндийн сайдын тушаалаар баталсан байна. | 10 | Эмч, мэргэжилтнийг сургах төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу сургалт зохион байгуулсан байна. | 35 | Эмч, мэргэжилтнийг сургах төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу сургалт зохион байгуулсан байна. | 150 | ЭМЯ Мэргэжлийн салбар зөвлөл ХӨСҮТ | ЭМБ |
| Эмч, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхжуулах, тасралтгүй сургах, өөрөө суралцах аргачлалд тулгуурласан сургалтын шинэ тогтолцоог нэвтрүүлэх. | 1 | Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд тандалт, илрүүлэг, оношилгоо, эмчилгээний талаар тасралтгүй сургалт зохион байгуулах. | 2022-2025 | Дэмжих сан Орон нутгийн төсөв | 300 | | | | | Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтэнд зориулсан, мэргэжил бүрээр тусгайлсан сургалтын модуль бэлтгэх, багц цагийн сургалтын хөтөлбөрт оруулж, батлуулсан байна. /Багц цаг авах боломжтой өөрөө суралцах модуль боловсруулж, нэвтрүүлнэ/ | 50 | Нийслэл, дүүрэг, аймгийн нэгдсэн эмнэлэг, БОЭТ-ийн Молекул биологийн лабораторийн эмч нарт сургалт зохион байгуулсан байна. (Вирусийн ачаалал тодорхойлох шинжилгээ) | 100 | Лавлагаа шатлалын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд гепатитын вирусийн халдварын оношилгоо, эмчилгээ, хяналт болон ДЭМБ-ын халдварыг таслан зогсоох, баталгаажуулах үнэлгээний талаарх тасралтгүй сургалт хийсэн байна. | 150 | ЭМЯ Мэргэжлийн салбар зөвлөл | ХӨСҮТ ХСҮТ ЭХЭМҮТ ЭМХТ ЭМДЕГ ОУБ |
| | 2 | Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын эмч эмнэлгийн мэргэжилтнүүдэд тандалт, илрүүлэг, оношилгоо, эмчилгээний талаар тасралтгүй сургалт зохион байгуулах. | 2022-2025 | Дэмжих сан ДЭМБ ОУБ | 300 | | | Анхан шатны ЭМБ-ын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд зориулсан Архаг гепатитын эмчилгээний заавар андройд/IOS аппликэйшнийг хэрэглээнд нэвтрүүлэх сургалт зохион байгуулсан байна. | | Сум, өрхийн ЭМТ-ийн эмч нарыг гепатитын вирусийн халдварын тандалт, илрүүлэг, (түргэвчилсэн шинжилгээ), оношилгоо, эмчилгээ, ДЭМБ-ын халдварыг таслан зогсоох, баталгаажуулах үнэлгээний талаарх тасралтгүй сургалтад хамруулсан байна. | 150 | Анхан шатны ЭМБ-ын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд зориулсан Архаг гепатитын эмчилгээний заавар андройд/IOS аппликэйшнийг хэрэглээнд нэвтрүүлэх сургалт зохион байгуулсан байна. | | Сум, өрхийн ЭМТ-ийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд ажлын байран дээр тасралтгүй сургалт зохион байгуулсан байна. | 150 | ЭМЯ Мэргэжлийн салбар зөвлөл | ХӨСҮТ ХСҮТ ЭХЭМҮТ ЭМХТ ЭМДЕГ ОУБ |

| | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 3 | Гепатитын вирусийн халдварын тархалтыг таслан зогсоох асуудлаарх үндэсний зөвлөгөөн зохион байгуулах. | 2022-2025 | ДЭМБ | 300 | | | | Үндэсний зөвлөгөөн зохион байгуулсан байна. | 100 | Үндэсний зөвлөгөөн зохион байгуулсан байна. | 100 | Үндэсний зөвлөгөөн зохион байгуулсан байна. | 100 | ЭМЯ | ХӨСҮТ ХСҮТ НЭМҮТ ЭХЭМҮТ |
| Лабораторийн чадавхийг сайжруулах замаар гепатитын вирусийн халдвар, элэгний хатуурал, элэгний хорт хавдрын оношилгооны баталгаа хангах, орон нутагт вирусийн ачаалал тодорхойлох шинжилгээг тогтмолжуулах. | 1 | Гепатитын вирусийн халдвар илрүүлэх түргэвчилсэн оношлуурын үнэлгээ хийх. | 2022-2025 | ДЭМБ Дэмжих сан Орон нутгийн сан | 250 | | | | Оношлуурыг үнэлгээнд хамруулах эрх зүйн орчныг бий болгоно. Оношлуурын үнэлгээг хийсэн байна. | 100 | Оношлуурын үнэлгээг хийсэн байна. | 50 | Оношлуурын үнэлгээг хийсэн байна. | 100 | ХӨСҮТ МСЗ | Анхан болон лавлагаа ЭМБ |
| | 2 | Лабораторийн шинжилгээний орчин үеийн арга, оношилгооны шинэ технологийг практикт нэвтрүүлж, үр дүнг тооцох. | 2022-2025 | Дэмжих сан ЭМД сан Орон нутгийн сан ОУБ | 21 тэрбум | | | | | | Лавлагаа төвүүдэд элэгний хорт хавдрын оношилгоог сайжруулан, хүний нөөцийг чадавхжуулсан байна. | 16 тэрбум | Гепатитын С вирусийн генотип тодорхойлох шинжилгээнд зорилтот бүлгийг хамруулсан байна. | 5 тэрбум | ЭМЯ ЭМДЕГ ЭЭХХЗГ | ЭМДҮЗ |
| | 3 | Гепатитын Дельта вирусийн халдварын ачаалал тодорхойлох, эмчилгээний хяналтын шинжилгээг Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх. | 2022-2025 | Эрүүл мэндийн даатгалын сан | 2.550 тэрбум | Илрүүлэг: 5 лаб, Идэвхжил тодорхойлох: 5 лаб | | | Гепатитын Дельта вирус илрүүлэх идэвхжил тодорхойлох шинжилгээ хийх аргачлалыг боловсруулж батална. Дельта вирус илрүүлэх, идэвхжил тодорхойлох болон эмчилгээний хяналтын шинжилгээний зардлыг ЭМДҮЗ-ийн холбогдох тогтоолд өөрчлөлт оруулсан байна. Гепатитын Дельта вирус илрүүлэх, идэвхжил тодорхойлох шинжилгээнд зорилтот бүлгийг хамруулсан байна. | 1 тэрбум | Гепатитын Дельта вирус илрүүлэх, идэвхжил тодорхойлох шинжилгээнд зорилтот бүлгийг хамруулсан байна. Хэрэгжилтийн явцад үнэлгээ хийнэ. | 1 тэрбум | Гепатитын Дельта вирус илрүүлэх, идэвхжил тодорхойлох шинжилгээнд зорилтот бүлгийг хамруулсан байна. Хэрэгжилтийн явцад үнэлгээ хийнэ. | 550 | ЭМЯ ЭМДЕГ ЭЭХХЗГ | ЭМДҮЗ |

| | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 4 | Гепатитын В, С, Дельта вирусийн хавсарсан халдвартай иргэнд хийх вирусийн идэвхжил тодорхойлох, эмчилгээний хяналтын шинжилгээг Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх. | 2022-2025 | Эрүүл мэндийн даатгалын сан | 8.5 тэрбум | ГВВ-41,1% ГСВ-40,9% | | | Гепатитын В, С, Дельта вирусийн хавсарсан халдвартай иргэнд хийх вирусийн идэвхжил тодорхойлох, эмчилгээний хяналтын шинжилгээний зардлыг ЭМДҮЗ-ийн холбогдох тогтоолд өөрчлөлт оруулан санхүүжүүлэх асуудлыг шийдвэрлүүлсэн байна. Гепатитын В, С, Дельта вирусийн хавсарсан халдвартай зорилтот бүлгийг вирусийн идэвхжил тодорхойлох, эмчилгээний хяналтын шинжилгээнд хамруулсан байна. | 1.5 тэрбум | Гепатитын В, С, Дельта вирусийн хавсарсан халдвартай иргэдийг вирусийн идэвхжил тодорхойлох, эмчилгээний хяналтын шинжилгээг Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэн байна. Гепатитын В, С, Дельта вирусийн хавсарсан халдвартай зорилтот бүлгийг вирусийн идэвхжил тодорхойлох, эмчилгээний хяналтын шинжилгээнд хамруулсан байна. | 5 тэрбум | Гепатитын В, С, Дельта вирусийн хавсарсан халдвартай иргэдийг вирусийн идэвхжил тодорхойлох, эмчилгээний хяналтын шинжилгээг Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэн байна. Гепатитын В, С, Дельта вирусийн хавсарсан халдвартай зорилтот бүлгийг вирусийн идэвхжил тодорхойлох, эмчилгээний хяналтын шинжилгээнд хамруулсан байна. | 2 тэрбум | ЭМЯ ЭЭХХЗГ ЭМДЕГ | ЭМДҮЗ |
| | 5 | Гепатитын вирусийн илрүүлэх, идэвхжил тодорхойлох шинжилгээ хийдэг эрүүл мэндийн байгууллагын тоог нэмэгдүүлэх | 2022-2025 | Дэмжих сан ОУБ ЭМД сан Орон нутгийн төсөв | 3.1 тэрбум | | | | Гепатитын В, С, Дельта вирусийн халдварын илрүүлэг, идэвхжил тодорхойлох шинжилгээ хийдэг лабораторуудыг гадаад чанарын хяналтад хамруулсан байна. | 100 | Хөсүт-ийн гепатит энтеровирусийн лабораторийг гепатитын оношлогооны лавлагаа лабораторийн статустай ажиллах хууль эрх зүйн орчныг бүрдүүлэн, сайдын тушаалаар батлан, оношлогооны чадавхийг нэмэгдүүлэн, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, хүний нөөцийг нэмэгдүүлэн, сургалтад хамруулсан байна. | 1 тэрбум | Аймгийн нэгдсэн эмнэлэгт гепатитын вирусийн ачаалал тодорхойлох шинжилгээний тогтвортой байдлыг хангасан байна. Аймгийн нэгдсэн эмнэлэгт гепатитын вирусийн ачаалал тодорхойлох шинжилгээнд дэмжлэгт хяналтыг хийсэн байна. | 2 тэрбум | ЭМЯ ХӨСҮТ ЭМДЕГ | ЭМДҮЗ |
| Эрүүл мэндийн даатгалаар хөнгөлөх, эм хангамжийн олон улсын хөтөлбөрт хамрагдах зэргээр гепатитын В, С, Дельта вирусийн эсрэг эмийн зах зээлийн үнийг бууруулан, иргэнд учрах санхүүгийн дарамтыг багасгаж, [illegible] | 1 | Гепатитын В, С вирусийн эсрэг эмийн нөөцийг бүрдүүлэн, зах зээлийн хангамжийн тогтвортой байдлыг хангах. | 2022-2025 | Улсын төсөв Дэмжих сан ОУБ | 70 | Эмчилгээнд хамрагдсан хувь ГВВ-41,1% ГСВ-67,3% | | | Хяналтын эмч В вирусийн эсрэг эмийн жорыг улирал/хагас жилээр бичих боломжийг журам удирдамжаар зохицуулан бүрдүүлсэн байна. | 60 | Гепатитын В, С, Дельта вирусийн архаг халдварын оношилгоо эмчилгээний шинэчилсэн удирдамжид орсон вирусийн эсрэг эмийг ЭМД-аар хөнгөлөх эрх зүйн орчныг бүрдүүлсэн байна. | 10 | ЭМД-ын хөнгөлөлтөөр олгох эмийн жагсаалтад орсон гепатитын В, С, Дельта вирусийн эсрэг эмийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн нөхцөл байдлыг үнэлж, эмийн нөөцийг бүрдүүлнэ. | | ЭМЯ ЭМДЕГ | ЭЭХХЗГ |

| | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| хамралт, үр дүнг нэмэгдүүлэх. | 2 | Гепатитын Дельта вирусийн эсрэг эмчилгээний шинэ аргыг практикт нэвтрүүлэх. | 2022-2025 | ЭМД сан | 33 тэрбум | 10 дээш хувь | | | Дельта вирусийн эсрэг эмчилгээ ЭМД-аар хөнгөлөх эрх зүйн орчныг үе шаттай бүрдүүлнэ. Дельта вирусийн эсрэг эмчилгээг практикт шинээр үе шаттайгаар нэвтрүүлж эхэлсэн байна. | 3 тэрбум | Дельта вирусийн эсрэг эмчилгээ ЭМД-аар хөнгөлөх эрх зүйн орчныг үе шаттай бүрдүүлнэ. Дельта вирусийн эсрэг эмчилгээг практикт шинээр үе шаттайгаар нэвтрүүлсэн байна. | 15 тэрбум | Дельта вирусийн эсрэг эмчилгээг практикт шинээр нэвтрүүлсэн байна. | 15 тэрбум | ЭМЯ ЭМДЕГ ХӨСҮТ | ЭЭХХЗГ |
| **Зорилт 3: Цахим бүртгэлийн программыг хөгжүүлэх замаар гепатитын вирусийн цочмог болон архаг халдварын хяналтын тогтолцоог бүрдүүлнэ** | | | | | | | | | | | | | | | | |
| Гепатитын вирусийн халдварын илрүүлэг, оношилгоо, эмчилгээ, хяналтын цахим бүртгэлийг хэрэглэгчдэд ээлтэй болгон хөгжүүлэх, ашиглалтыг сайжруулах. | 1 | Гепатитын вирусийн халдварын илрүүлэг, эмчилгээ, хяналтын удирдамжийн дагуу одоогийн цахим бүртгэлийн программыг хөгжүүлж тандалтыг сайжруулах. | 2022-2025 | Улсын төсөв Дэмжих сан ОУБ | 220 | | | | Халдварт болон халдварт бус өвчний эрт илрүүлгийн цахим бүртгэлийг уялдуулсан байна. | 20 | Элэг бүтэн Монгол хөтөлбөрийн цахим бүртгэл (гепатитын вирусийн цочмог болон архаг халдварын илрүүлэг, оношилгоо, эмчилгээ, хяналт) мэдээллийн программыг уялдуулж эрүүл мэндийн нэгдсэн санд нэгтгэх, ЭМХТ-д нэгтгэсэн байна (цахим программд элэгний хатуурал, хавдрын нөхцөл шалтгааны оношийг оруулах техникийн нөхцөл бололцоог бүрдүүлэх). | 100 | ЭМДЕГ болон эрүүл мэндийн байгууллагууд хоорондын мэдээллийн системийг нэгтгэх, эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийн шалгуур үзүүлэлтийг оношилгоо, эмчилгээний удирдамжтай уялдуулсан байна. | 100 | ЭМЯ ЭМХТ НЭМҮТ | Аймаг нийслэлийн ЭМГ, НЭ |
| | 2 | Цахим програмыг ашиглах, мэдээллийн цахим сангийн нууцлал, аюулгүй байдлыг хангах талаар, мэргэжил, арга зүйгээр хангах, программын ашиглалтад эрүүл мэндийн байгууллагын удирдлагаас хяналт тавих. | 2022-2025 | Улсын төсөв | 105 | | | | Мэдээллийн системийн ашиглалтын цахим гарын авлага, видео хичээл боловсруулсан байна. | 30 | Мэдээллийн системийн ашиглалтын талаар сургалтыг эрүүл мэндийн ажилтнууд, статистик эмч нарт зохион байгуулсан байна. | 35 | Мэдээллийн системийн ашиглалтын талаар сургалтыг эрүүл мэндийн ажилтнууд, статистик эмч нарт зохион байгуулсан байна. | 40 | ЭМХТ ХӨСҮТ | Эрүүл мэндийн байгууллага |
| Гепатитын В, С вирусийн архаг халдвартай өвчтөний оношилгоо, вирусийн эсрэг шууд үйлчилгээтэй эмийн эмчилгээний хяналтын мэдээллийг элэгний хатуурал, хорт хавдрын эрэн дуудах тогтолцоонд ашиглах боломжийг бүрдүүлэн, цогц | 1 | Хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан эсхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгооны мэдээллийн санд суурилан В, С, Дельта вирусийн архаг халдвартай өвчтөний эмчилгээний хяналтын мэдээллийн санг бүрдүүлэх. | 2022-2025 | Улсын төсөв, ДЭМБ, ЭМДЕГ | 90 | | | | Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг шинжилгээгээр В, С, Дельта вирусийн архаг халдвартай оношлогдсон өвчтөний эмчилгээ, эмчилгээний хяналтын лабораторийн шинжилгээний үр дүн бүхий мэдээллийн санг бүрдүүлсэн байна. /Эмчилгээний үр дүнгийн тооцох каскад гаргах боломжтой байх/. | 25 | Улс, аймаг орон нутгийн түвшинд гепатитын архаг халдварын эмчилгээний үр дүнг тооцож гаргасан байна. | 30 | Улс, аймаг орон нутгийн түвшинд гепатитын архаг халдварын эмчилгээний үр дүнг тооцож гаргасан байна. | 35 | ЭМХТ ХӨСҮТ ХСҮТ ЭМХТ | Эрүүл мэндийн байгууллага |

| | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| мэдээллийн санг бий болгох. | 2 | Гепатитын В, С, Дельта вирусийн архаг халдвар, түүний шалтгаант элэгний хатуурал, хорт хавдар, нас баралтыг бүртгэх тооцоолон, эмнэлэгт суурилсан харуулдан тандалтын тогтолцоог бий болгох. | 2022-202 | ДЭМБ ДЭмжих сан | 95 | 5.5 (нас баралт 10,000 хүн амд, 2015) | Гепатитын В, С, Дельта вирусийн цочмог болон архаг халдвар, элэгний хатуурал, хорт хавдар, нас баралтын тохиолдлын тандалтын тогтолцоог бий болгох ажлын хэсэг байгуулж, хэлэлцүүлэг хийсэн байна. | | Гепатитын В, С, Дельта вирусийн цочмог болон архаг халдвар, элэгний хатуурал, хорт хавдар, нас баралтын тохиолдлын тандалтын тогтолцоог бий болгох журмыг боловсруулж баталсан байна. | 30 | Тандалтын нэгжийн эмч, мэргэжилтнийг сургана. | 30 | Гепатитын В, С, Дельта вирусийн шалтгаант элэгний хорт хавдар, элэгний хатуурал, элэгний архаг өвчлөлийг бүртгэсэн байна. Гепатитын В, С, Дельта вирусийн архаг халдвартай өвчтөний эмчилгээний хяналтын мэдээллийн санг хорт хавдрын эрсэн дүудах тогтолцоонд нэвтрүүлсэн байна. | 30 | ЭМЯ ЭМХТ ХӨСҮТ ХСҮТ | Эрүүл мэндийн байгууллага |
| **Зорилт 4: Гепатитын В, С, Дельта вирусийн халдвар, элэгний хатуурал, хорт хавдрын тандалт, оношилгоо, эмчилгээний чиглэлээр хийх эрдэм шинжилгээ, судалгааны ажлын тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, үр дүнг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд нэвтрүүлнэ** | | | | | | | | | | | | | | | | |
| Гепатитын В, С, Дельта вирусийн халдварын үнэлгээг хийн судалгааны ажлыг эрчимжүүлнэ. | 1 | Олон улсын байгууллагатай хамтран вируст гепатитын тархалтыг таслан зогсоосныг баталгаажуулах урьдчилсан үнэлгээ хийх. | 2022-2025 | ДЭМБ ОУБ | 80 | | "Гепатитын В, С вирусийн халдварын тархалтыг таслан зогсоох" ДЭМБ-ын зорилтын хүрээнд өвчлөлийн мэдээлэлд дүн шинжилгээ хийнэ. | | Гепатитын В, С вирусийн халдварын тархалтыг таслан зогсоосныг баталгаажуулах үнэлгээний бэлтгэл ажлыг хангах, үнэлгээний багийг арга зүйгээр хангах, үнэлгээ хийсэн байна. | 45 | Гепатитын В, С вирусийн халдварын тархалтыг таслан зогсоосныг баталгаажуулсан байна. | 20 | Гепатитын В, С вирусийн халдварын тархалтыг таслан зогсоосныг баталгаажуулсан байна. | 15 | ЭМЯ ХӨСҮТ | АШУҮИС Аймаг нийслэлийн ЭМГ, НЭ |
| | 2 | Эрүүл мэндийн салбарын эрдэмтэдтэй хамтран гепатитын вирусийн халдвар, элэгний хатуурал, хорт хавдрын оношилгоо, эмчилгээний эрдэм шинжилгээ, судалгааны ажлын тэргүүлэх чиглэлийг тодорхойлох. | 2022-2025 | Улсын төсөв, ДЭМБ ОУБ | 190 | 0-5 хүртэлх 0.53 хувь | Гепатитын вирусийн халдвар, элэгний хатуурал, хорт хавдрын оношилгоо, эмчилгээний талаарх судалгааны ажлын тэргүүлэх чиглэлийг тодорхойлсон байна | 10 | Гепатитын В вирусийн халдварын эсрэг дархлал тогтоцын түвшингийн судалгаар 0-5 хүртэлх насны хүүхдүүдийн дунд хийсэн байна | 55 | 5-18 хүртэлх настай хүүхдүүдэд гепатитын В вирусын дархлал тогтоцыг үзэж вакцины дархлал сэргээх тун хийх насыг тодорхойлсон байна. | 60 | Гепатитын В, С вирусийн халдвартай эхээс төрсөн хүүхдүүдэд халдварын түвшин тодорхойлох судалгаа хийсэн байна. | 65 | ХӨСҮТ Мэргэжлийн салбар зөвлөл | АШУҮИС Аймаг нийслэлийн ЭМГ, НЭ |

Эрүүл мэндийн сайдын 2022 оны
12 сарын 05 өдрийн А/574 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

**“Элэг бүтэн Монгол” арга хэмжээний шалгуур үзүүлэлт**

| Шалгуур үзүүлэлт | Суурь үзүүлэлт 2020 он | Хүрэх түвшин | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 2022 он | 2023 он | 2024 он | 2025 он |
| **Үр нөлөөний шалгуур үзүүлэлт:** | | | | | |
| Тав хүртлэх насны хүүхдийн дундах гепатитын В вирусийн [HBsAg+] тархалт | 0.53% (2011) | 0.5% | 0.45% | 0.4 | <0.3 % |
| 100,000 хүн ам дахь гепатитын В вирусийн өвчлөлийн шинэ тохиолдол | 1.1 | 1.0 | 0.8 | 0.6 | 0.4 |
| 100,000 хүн ам дахь гепатитын С вирусийн өвчлөлийн шинэ тохиолдол | 3.4 | 3.2 | 3.0 | 2.9 | 2.7 |
| Гепатитын В, С вирусийн халдвараас үүдэлтэй элэгний хорт хавдрын шалтгаант нас баралтын түвшин (100,000 хүн амд) | 5.5 (2015) | 5.4 | 5.2 | 4.9 | 4.5 |
| HBsAg эерэг эхээс төрсөн хүүхдийн илрүүлгийн хувь | 0 | 10% | 30% | 60% | 80% |
| **Үр дүнгийн шалгуур үзүүлэлт:** | | | | | |
| Нярайг төрсний дараах 24 цагийн дотор гепатитын В вирусийн эсрэг вакцинаар дархлаажуулсан хувь | 98.5 % | 98.6 % | 98.7 % | 98.8% | 99.0 % |
| Тавт вакцины бүрэн тунгийн хамралтын хувь [товлолын дагуу, гурван тунд хамрагдсан байх] | 96.4% | 96.5% | 96.6% | 96.7% | 96.8% |
| Гепатитын В вирусийн архаг халдвартай эхээс төрсөн нярайг 12 цагийн дотор В вирусийн эсрэг вакцин, иммуноглобулиныг хавсарч хэрэглэсэн хувь | - | 30% | 50% | 70% | 90% |
| Гепатитын В, С, Дельта вирусийн шалтгаант элэгний хорт хавдар, элэгний хатуурлын хувь | Тодор-хойгүй | Тодор-хойгүй | Тодор-хойлно | Тодор-хойлно | Тодор-хойлно |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Тухайн жилд гепатитын В вирусийн архаг халдвартай гэж оношилогдсон иргэдээс вирусийн эсрэг эмчилгээнд хамрагдсан өвчтөний эзлэх хувь | 41% | 45% | 50% | 55% | 60% |
| Тухайн жилд гепатитын С вирусийн архаг халдвартай гэж оношилогдсон иргэдээс вирусын эсрэг эмчилгээнд хамрагдсан өвчтөний эзлэх хувь | 60% | 65% | 70% | 80% | 90% |
| Тухайн жилд гепатитын Дельта вирусийн халдвартай гэж оношилогдсон иргэдээс вирусын эсрэг эмчилгээнд хамрагдсан өвчтөний эзлэх хувь | 10% | 20% | 30% | 40% | 50% |
| Гепатитын В вирусийн архаг халдвартай амьдарч байгаа иргэдээс оношилогдсон хүний эзлэх хувь | 53% | 60% | 65% | 75% | 80% |
| Гепатитын С вирусийн архаг халдвартай амьдарч байгаа иргэдээс оношилогдсон хүний эзлэх хувь | 25% | 40% | 60% | 70% | 80% |
| Төрийн болон олон улсын байгууллагын санхүүжилтээр хийгдсэн эрдэм шинжилгээ, судалгааны тоо | 1 | 1 | 5 | 8 | 10 |